

Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/		2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар		“Шивээ-Овоо” ХК, УБГ: 3212010001, ҮЦК: SHV 460 Утас: 976-7054-6571
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр		“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар		Уул уурхай - Хүрэн нүүрс олборлолт
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо		“Сүлд аудит” ХХК
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг		13 419 101 ширхэг энгийн хувьцаа
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр		Жилийн тайланг бэлтгэсэн: Д.Номин-Эрдэнэ-/Үйлдвэрийн эдийн засагч/, Хянасан: У.Занабазар / СЭЗХ-ийн дарга, Ерөнхий нягтлан бодогч/
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Эргэлтийн хөрөнгийн дүн 48,096,485,469.47 төгрөг Эргэлтийн бус хөрөнгийн дүн 71,818,930,865.95 төгрөг Нийт хөрөнгийн дүн 119,915,416,335.42 төгрөг Богино хугацаат өр төлбөрийн дүн 195,609,322,015.89 төгрөг Урт хугацаат өр төлбөрийн дүн 11,163,176,211.66 төгрөг Эздийн өмчийн дүн -86,857,081,893.13 төгрөг Өр төлбөр ба эздийн өмчийн дүн 119,915,416,335.42 төгрөг
	Орлогын тайлан	Борлуулалтын цэвэр орлого 125,706,617,144.56 төгрөг Борлуулалтын өртөг 112,245,118,277.24 төгрөг Татварын өмнөх ашиг 2,217,401,250.63 төгрөг Татварын дараах ашиг 1,772,785,327.55 төгрөг
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр өмчийн өөрчлөлтийн тайлан -86,857,081,892.13 төгрөг байна.
	Мөнгөн гүйлгээний тайлан	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн 12,222,940,850.75 төгрөг Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн -19,365,153,991.39 төгрөг Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн 13,299,432,216.27 төгрөг Бүх цэвэр мөнгөн гүйлгээний дүн 6,157,219,075.63 төгрөг Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 3,132,061,146.05 төгрөг Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 9,289,280,221.68 төгрөг

1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын хорооны дүгнэлт		
	2025 оны Санхүүгийн тайлангийн дүгнэлт нь “Хязгаарлалттай дүгнэлт”-тэй гарсан.		
1.2	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/		
	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шивээ Овоо” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ. Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн нөлөөг эс тооцвол “Шивээ Овоо” ХК-ийн 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.		
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас огссон үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл		
2.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Цэвэр ашгийн хувь	1.4%
		Өөрийн хөрөнгийн өгөөж	3.7%
		Нийт хөрөнгийн өгөөж	1.5%
2.2	Хөрвөх чадварын болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа	24.6%
		Түргэн хөрвөх чадварын харьцаа	0.11%
2.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	“Шивээ-Овоо” ХК нь Монгол Улсын дотоодын цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн нүүрсний нийт хэрэгцээний 21.7 хувийг хангадаг стратегийн ач холбогдол бүхий байгууллага юм. Тус компани нь Төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний 58.7 хувь, Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний 54.8 хувийг үйлдвэрлэдэг “ДЦС-4” ТӨХК-ийн нүүрсний хэрэгцээний 50.0 хувь, Улаанбаатар хотын зүүн бүсийн дулааны эрчим хүчийг үйлдвэрлэдэг “Амгалан ДС”-ын нүүрсний хэрэгцээний 60.0 хувийг тус тус ханган нийлүүлдэг. Мөн орон нутгийн дулааны эрчим хүч үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудыг эрчим хүчний зориулалттай хүрэн нүүрсээр тасралтгүй ханган ажиллаж байна.	
2.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил, үйлчилгээ байхгүй.	
2.5	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	2025 онд Голомт банкнаас 7.0 тэрбум төгрөгийн зээлийг хөрөнгө оруулалтын зориулалтаар авч зээлийн гэрээнд заагдсан хуваарийн дагуу төлбөрийг төлж байна.	
3	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/		
4	Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болно.		
	Цалин урамшууллын мэдээлэл		
	2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс бүх ажилчдын цалинг 10 хүртэлх хувиар нэмэгдүүлсэн. Сар бүр төлөвлөгөөний биелэлтээс хамаарч 30 хувийн нэмэгдэл цалингийн урамшуулал олгодог.		
5	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл		

	“Шивээ Овоо” ХК нь Монголын хөрөнгийн биржийн 2-р ангилалд багтдаг. Хувьцаа эзэмшигчдийн хурал “Шивээ Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Хурлаар хэлэлцсэн асуудал: - Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай; - Компанийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай; - Ногдол ашгийн талаар гаргасан шийдвэрийн танилцуулга; - Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай; - Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлантай танилцах; 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан танилцуулах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулахаар товлоод байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай; Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд: ТУЗ-ийн дарга: Ц.Төгсбуян ТУЗ-ийн ердийн Гишүүд: Д.Нямдэлгэр И.Батхүү Д.Мягмарсүрэн П.Билгүүн Л.Наранчимэг ТУЗ-ийн хараат бус Гишүүд: С.Цолмон Ц.Лхамсүрэн П.Баянсан <pre> graph TD A[Хувьцаа эзэмшигчид] --> B[Төлөөлөн удирдах зөвлөл] B --> C[Төлөөлөн удирдах зөвлөлийн хороо] subgraph C_Box [] direction TB C1[Аудитын хороо] C2[Нэр дэвшүүлэх хороо] C3[Цалин урамшууллын хороо] end C_Box --> D[Гүйцэтгэх захирал] D --> E[Шивээ Овоо ХК-ны ажилчид] </pre> Хувьцаа эзэмшигчдийн бүтэц: ■ ЭМХХК ■ Бусад хувьцаа эзэмшигчид
6	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл “Шивээ-Овоо” ХК-ийн үйл ажиллагаанд зах зээлийн дараах эрсдэлүүд тохиолдох өндөр магадлалтай байна. Үүнд: Компанийн борлуулж буй нүүрсний үнэ нь зах зээлийн чөлөөт өрсөлдөөнөөр бус, төрийн зохицуулалтаар тогтоогддог тул үнийн эрсдэл өндөр байна. Эрчим хүчний зохицуулах хорооноос 1 тонн нүүрсний борлуулалтын үнийг үйлдвэрлэлийн өртгөөс ихэнхдээ доогуур тогтоодог бөгөөд энэ нь компанийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болдог. Мөн компанийн бүтээгдэхүүний эрэлт нь дотоодын дулааны цахилгаан станцуудын хэрэгцээнээс шууд хамааралтай. Тухайлбал, ДЦС-4 ТӨХК болон Амгалан ДС зэрэг гол хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээ буурах, эсвэл төлбөрийн чадвар сулрах нь борлуулалтын орлого тасалдах эрсдэлийг бий болгодог. Түүнчлэн түлш, шатахуун, сэлбэг хэрэгслийн үнэ өсөх, нийлүүлэлтийн доголдол үүсэх нь үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлж, зах зээлийн нөхцөлд ашигт ажиллагааг бууруулах эрсдэлтэй. Цаашид эрчим хүчний салбарт сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх, нүүрсний хэрэглээг бууруулах бодлого хэрэгжих нь урт хугацаанд нүүрсний зах зээлийн эрэлтийг бууруулах боломжтой. Иймд дээрх хүчин зүйлс нь компанийн орлого, ашигт ажиллагаа болон санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх зах зээлийн эрсдэлийг бүрдүүлж байна.
7	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс, эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/

	Компанийн нийт хувьцаа эзэмшигчдийн тоо – 1561 хүн, хуулийн этгээд Үүнээс “Эрдэнэс Монгол” ХХК нийт хувьцааны 90 хувийг эзэмшдэг.
8	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл
	Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй болно.
9	Ногдол ашигийн мэдээлэл
	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 26/03 дугаар тогтоолоор “Шивээ Овоо” ХК-ийн санхүүгийн тайлангийн дагуу ногдол ашиг төлсний дараа төлбөрийн чадвартай байх нөхцөлийг хангаагүй тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.
10	Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
	Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг дарга, Шивээ овоо ХК-ийн хамтран ажиллах гэрээний дагуу Засаг даргын тамгын газартай хамтран “Малчдын дуу хоолойг сонсож тэдний өмнө тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг судлах, 1, 2 дугаар багийн малчин болон мал бүхий өрх хоорондын хамтын ажиллагааг сайжруулах “Малчдын зөвлөгөөн”-ийг хамтран зохион байгууллаа. Олон улсын Ахмадын баярын энэ өдөр Эрхэм хүндэт ахмад буурлуудынхаа амар амгаланг айлтган Монгол Улсын бүтээн байгуулалт, хөгжлийн төлөө залуу нас, оюун ухаан, мэдлэг чадвар, сэтгэл зүрхээ харамгүй зориулж ирсэн ахмад буурлууддаа “Олон улсын ахмадын баяр”-ын өдрийн мэндийг хүргэн компанийн зүгээс эрүүл мэндийн үйл ажиллагаа зохион байгууллаа.
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Г.БАТСУУРЬ Албан тушаал: “ШИВЭЭ ОВОО” ХК-ийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: (тамга/тэмдэг)	Овог, нэр: У.ЗАНАБАЗАР Албан тушаал: “ШИВЭЭ ОВОО” ХК-ийн Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч Гарын үсэг:  (тамга/тэмдэг)
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Д.НОМИН-ЭРДЭНЭ Албан тушаал: “ШИВЭЭ ОВОО” ХК-ийн Санхүү, эдийн засгийн хэлтсийн үйлдвэрийн эдийн засагч Гарын үсэг: ... <i>Д. Номин-Эрдэнэ</i> ... /тамга тэмдэг/	